

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

МЛАДА БОЛЭСЛАВ

**ДАХЬ БАГА СУРГУУЛИЙН
БОЛОВСРОЛЫН СИСТЕМ**

ГАДААД СУРАГЧИД, ТЭДНИЙ ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛАВ



МЛАДА БОЛЭСЛАВ ДАХЬ БАГА СУРГУУЛИЙН БОЛОВСРОЛЫН СИСТЕМИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

ГАДААД СУРАГЧИД, ТЭДНИЙ ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛАВ

Хүндэт эцэг эхчүүд, хөөрхөн багачууд аа,

Шилжин ирсэн орчныхоо талаар ойлголт авах, мэдлэг баримжаатай болоход тань туслах зорилгоор чехийн боловсролын системийн талаарх үндсэн мэдээллийг энэхүү товхимолд товч бөгөөд ойлгомжтой хэлбэрээр оруулав.

Мөн Млада Болэслав хот дахь бүх бага сургуулийн талаарх мэдээллээс гадна гадаад хүний тань хувьд шинэ эсвэл өөр утга агуулгатай байж болох зарим үгсийн тайлбарыг эндээс үзэж болно.

Эдгээр мэдээлэл нь таны хүүхэд шинэ нутагт хурдан дасан зохицох, сургуультай тогтоосон харилцаа тань улам сайжрахад тус болно гэдэгт итгэж байна.

Бидний эн тэргүүний зорилго бол харилцан ойлголцох, сэтгэл ханамжтай байх, юуны өмнө таны хүүхэд амжилттай суралцахад оршиж байгаа билээ.

Та бүхэнтэй хичээлийн танхимд уулзацгаая.

Даниэл Марэк, магистр
Млада Болэслав хотын орлогч дарга

Пэтр Достал, магистр
*Боловсрол, соёл, биеийн тамирын
хэлтсийн эрхлэгч*

АГУУЛГА

Млада Болэслав дахь бага сургуулийн үндсэн мэдээлэл	3
Хүүхдээ бага сургуульд хэрхэн бүртгүүлэх вэ?	9
Тогтмол хэрэглэгддэг үгс	10
Млада Болэслав дахь бага сургуулиуд	12
1. Бага сургууль, Komenského náměstí 76, 293 01 Mladá Boleslav	12
2. Бага сургууль, Komenského náměstí 91, 293 01 Mladá Boleslav	13
Др. Эдвард Бэнэшийн бага сургууль, Laurinova 905, 293 01 Mladá Boleslav	14
Т. Г. Масарикийн бага сургууль, цэцэрлэг, Svatovítská 574, 293 01 Mladá Boleslav	16
5. Бага сургууль, цэцэрлэг, Dukelská 1112, 293 01 Mladá Boleslav	17
6. Бага сургууль, цэцэрлэг, Jilemnického 1152, 293 01 Mladá Boleslav	18
7. Бага сургууль, Václavkova 1082, 293 01 Mladá Boleslav	19
8. Бага сургууль, цэцэрлэг, Václavkova 1040, 293 01 Mladá Boleslav	20
9. БС Пастэлка, 17. listopadu 1325, 293 01 Mladá Boleslav	22
Масарикийн бага сургууль, “Дэбрж” цэцэрлэг, Bakovská 7, 293 01 Mladá Boleslav - Debrž	24
Манай бүс нутаг дахь гадаад иргэдэд үйлчлэх байгууллагууд	25
Талархал	27

МЛАДА БОЛЭСЛАВ ДАХЬ БАГА СУРГУУЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



- 6 нас хүрсэн хүүхдүүд сургуульд элсэн орж суралцаж эхэлнэ.
- Сургуульд заавал суралцах ёстой хугацаа 9 жил байдаг. Үүн дээр сургуулийн өмнөх бэлтгэл ангийн нэг жил нэмж тооцогддогийг мэдэж байх хэрэгтэй.
- Хүүхдүүдийг 1-р түвшний буюу 1-5-р анги, 2-р түвшний буюу 6-9-р анги гэж насаар нь ангилж сургана.
- Хичээлийн жил 9-р сарын 1-нд эхэлж 6-р сарын 30-нд (хэрвээ ажлын өдөр бол) дуусна.
- БНЧУ-д бага сургуулиудыг ихэвчилэн орон нутгийн харьяат хот суурин (гэхдээ хувийн, улсын, сүмийн гэх мэт сургуулиуд байдаг) газар эрхлэнэ, дунд сургуулиуд мужуудын харьяанд орно.
- Бага сургуулийн буюу суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй. Энэ үүргийг биелүүлээгүй тохиолдолд хуулийн хариуцлага хүлээнэ.

Амралт, баярын өдрүүд, захирлын чөлөө

Улс даяар тэмдэглэдэг баярын өдрүүдэд чехийн сургуулиуд мөн амардаг. Түүнчилэн захирлын чөлөө олгон сургуулийн хүүхдүүдийг амраах эрхийг захирал эдэлдэг. Ийм чөлөөг захирлын чөлөө гэх бөгөөд сургууль хариуцагч байгууллага батлах ёстой.

БНЧУ-д сургуулийн зуны амралт хоёр сар (долоо, наймдугаар сар) байдаг. Мөн Зул сарын үеэр (12.23 – 1.3.) амрана. Хаврын амралт долоо хоног байх бөгөөд 2-р сараас 3-р сарын хооронд тохионо. Бүс нутгууд сургуулийн хүүхдүүдийг өвлийн спортоор хичээллэх, амарч алжаалаа тайлахад нь зориулж ээлжээр амраадаг.

Хичээлийн ирц

БНЧУ-д хүүхдүүд хичээлдээ тогтмол явах ёстой. Мөн сургуулийн эсвэл төрийн зүгээс зохицуулагдан зайнаас суралцаж буй үед ч тогтмол оролцож байх үүрэгтэй.

Хүүхэд хичээлд ирэхгүй шалтгааныг эцэг эх нь заавал мэдэгдэх ёстой. Тодорхой шалтгаантай тохиолдолд эмчийн магадлагаа авчрахыг сургууль шаардаж болно. Чөлөө авах асуудлыг сургууль бүр дотоод журмаараа зохицуулна, журам мөрдөхгүй байх нь (ж.нь: зөрчил гаргах) сахилга батын арга хэмжээ авах үндэслэл болно.

Гэрчилгээ

Гэрчилгээ нь сурагчийн тодорхой хугацааны үнэлгээ бөгөөд хагас жил тутамд буюу 1-р сарын 31, 6-р сарын 30-нд (хичээлийн өдөр таарвал) хүүхдүүдэд олгоно. Сурагчийн мэдлэг, зүтгэлийг 1-5 хүртэлх дүнгээр үнэлэх бөгөөд хамгийн сайн нь 1, хангалтгүй нь 5 гэсэн дүн байдаг.

Түүнчилэн сурагчийн сайн болон сул тал, хичээл зүтгэл, юунд анхаарах талаарх зөвлөгөөг багш гэрчилгээнд бичнэ. Дүгнэх аргачлалыг сургуулийн захирал шийдвэрлэнэ.

Гэрчилгээг нямбайлан хадгалах нь зүйтэй.

Бага сургуулийн хүүхдүүд ямар үүрэгтэй вэ?

Сурагчдын наад захын үндсэн үүрэг нь:

- хичээлдээ тогтмол ирж байх,
- сургуулийн журмыг дагаж мөрдөх,
- хичээлийн хэрэгслээ авчирч байх,
- гэрийн даалгавраа хийж байх,
- хамт суралцагчид, насанд хүрэгсэдтэй хамтран ажиллаж байх,
- биеэ зөв авч явах, ёс зүйг мөрдөх.

Эцэг эх ямар үүрэгтэй вэ?

- Сургууль эцэг эхтэй харилцдаг „Bakaláři“ хэмээх онлайн системээр өдөр тутам орж шалгаж байх,
- Гэрийн даалгавар болон бусад үүргийн биелэлтэд хяналт тавих,
- Ангийн, бусад хичээлийн багш нар, сургуулийн захиралтай хамтран ажиллах,
- Чөлөө болон хичээлд ирэхгүй бусад зүйлийг цагт нь мэдээлж байх ,
- Сурагчийн хичээлийн наад захын хэрэгслүүдийг бэлдэх,
- Ёс зүйг баримтлах, соёлтой зөв байх.

Багш нарын үүрэг, ангийн багш болон бусад хичээлийн багш нарын ялгаа

Чех улсын боловсролын системд багш хүн нэр хүндтэй бөгөөд боловсролын хөтөч болдог юм.

Ангийн багш өөрийн даасан ангийг хариуцаж сурагчдынхаа хичээлийн ирц, сахилга бат зэрэг асуудлыг шийднэ. Багш бол сурагч болон эцэг эхийн холбоо байдаг. Бусад багш нар зөвхөн хариуцсан хичээлээ заана.

Ангийн хурал

Энэ нь багш, эцэг эхчүүд оролцсон хурал. Жилд 2 удаа, гэхдээ нэг, хоёрдугаар ангийнханд үүнээс олон удаа хуралдах нь байдаг. Эцэг эх энэ хуралд заавал оролцох ёстой, хуралд ирээгүй бол уулзах өөр тов тогтоох, эсвэл мэдээлэл дамжуулах үүрэг багшид байхгүй.

Багш онцгой тохиолдолд эцэг эхтэй хувиараа уулзах хүсэлт гаргаж болно. Мөн Гадаадын иргэдэд туслах төвийн болон координаторын тусламжтайгаар орчуулагч олж эцэг эхтэй хамт уулзалтад ирэхийг зохицуулж болно.

Ангийн хурал дээр сурагч тус бүрийн дүн, хамт олны тухай, хүүхдүүд хоорондын харьцаа, сайжруулах зүйлс, эцэг эх юуг бэлдэх, ямар арга хэмжээ зохиогдох зэрэг мэдээллийг өгдөг.

Хичээл бүрийг өөр багш заадаг 2-р түвшний ангиудын хуралд эсвэл багш нар тухайн ангийн хуралд орж сурагчдын талаар мэдээлэх, эсвэл эцэг эх тухайн багшийн хичээлийн танхимд очиж уулзан хүүхдийнхээ талаар асууна.

Ёс зүйгүй байдал

Иргэний хууль болон сургуулийн журамд хүмүүжлийн ямар хэлбэрийг хүлээн зөвшөөрөх, ямар байдал хууль болон сургуулийн дотоод журамтай зөрчилдөхийг тодорхойлсон байдаг. Сургуулийн журмыг зөрчсөн ямар ч тохиолдолд дүн бууруулах, хувийн хэрэгт тэмдэглэх зэргээр сахилга батын арга хэмжээ авагдана. Ёс зүйгүй үйлдэлд бусдын бүтээл хулгайлах, хуулах, худал ярих, бусдыг гадуурхаж дарамтлах, багш болон бусад сурагчтай бүдүүлэг харьцах зэрэг орно.

Хичээлийн хуваарь гэж юу вэ, хэрхэн мөрдөх вэ?

Чехийн сургуулиудад чех хэл, математик, биеийн тамир г.м. хичээлүүдээр төлөвлөгөө зохиодог. Хичээлийн төрлөөр цагийн хуваарь гаргана. Ямар хичээл хэдэн цаг орох, юу бэлдэх ёстойг сурагч бүр тодорхой мэдэж байдаг. Хичээлийн хуваарийнхаа дагуу дэвтэр номоо бэлдэж сургуульдаа явна.

1-р түвшний ангиудад хичээл хөнгөн хялбардуу байх бөгөөд ихэвчлэн үдээс өмнө 4-5 цаг хичээллэнэ. 3-р ангиас эхлэн долоо хоногт нэгээс хоёр удаа үдээс хойш орох хичээл нэмэгдэнэ. Энэ ангиудад сурагч өөрийн сонголтоор хичээллэхгүй, харин бүх хичээлд сурагчид жигд оролцох ёстой. 2-р түвшний ангийн сурагчид үдээс хойш хичээллэх нь нэмэгдэх бөгөөд өөрийн сонирхлоор зарим хичээлийг сонгож үзэх боломжтой болдог.

1-р түвшний ангид нэг багш бүх хичээлийг заана. 2 дахь түвшний ангид хичээлийн төрөл нэмэгдэж тус бүрээр нь өөр багш заана. Гэхдээ 1-2-р анги, 3-5-р анги, 6-9-р ангиуд өөрийн анги даасан багштай..

Хичээлийн дараах сургалт

Хуваарьт хичээлээс бусад хичээл сургалтад хүүхэд заавал суралцах, сургууль үүнийг зохицуулах албагүй. Хэлний сургууль зэрэг бие даасан байгууллагууд төлбөртэй сургалт зохион байгуулж сурагчид чөлөөт цагаараа спорт, урлаг, гар бүтээлийн хичээл сургалтад хамрагдаж болно.



1 ба 2-р түвшний ялгаа

Бага сургууль хоёр түвшинд хуваагдана. Нэгдүгээр түвшин нь 1-5-р ангийг, хоёрдугаар түвшин 6-9-р ангийг хамрана. Хичээлтйн төрөл, агуулга, хичээл үргэлжлэх хугацаа, сонгох боломж зэргээрээ ялгаатай.

“Бакаларжи (Bakaláři)” онлайн талбар

Энэ нь сургууль, сурагч, эцэг эх хоорондын онлайн харилцааны талбар юм. Бакаларжийн тусламжтайгаар сургууль болон эцэг эх захиа мэдээлэл илгээх, хүлээн авах боломжтой. Зарим сургууль 2-р дугаар ангиас эхлэн Бакаларжийн оронд харилцах дэвтэр ашигладаг.

Энэхүү харилцах онлайнаар орж **ӨДӨР БҮР ШАЛГАХ** нь сурагч, эцэг эх бүрийн үүрэг. Бакаларж орж мэдээлэл үзээгүй бол уучлах шалтгаан болохгүй.

Энд дараах зүйлсийг мэдэж авч болно:

- Сургуулийн үйл ажиллагаа,
- Хичээл сургалтын өөрчлөлт,
- Дараагийн өдөр болох чухал үйл явдлын мэдээлэл,
- дүн,
- гэрийн даалгавар,
- ангийн хурал болон бусад мэдээлэл.

Хичээлийн жилийн эхэнд эцэг эх, хүүхдэд нэвтрэх нэр, нууц үг өгнө. Өөрийн гар утсандаа аппликэшн суулгаж байнга ашиглах боломжтой болно. Эдгээр мэдээллээ алдах, мартаx үед сургуулийн нарийн бичгийн даргад хандаж шинээр авна.

Завсарлага

Хичээл бүрийн дараа 10 минутын завсарлагатай. Хоёр хичээлийн дараа их завсарлага болж хүүхдүүд цай уух цаг гарна. Мөн завсарлагаанаар бие засаж болно. Гэхдээ хүүхэд хичээлийн үеэр бие засах шаардлага гарвал багшдаа хэлэн хичээлээс гарч болно.

Үдийн хоол

Сургууль бүр хоолны танхимтай. Сурагчид үдийн хоол идэх бүртгэлээ хоолны танхимд хийнэ. Үдийн хоолны үнийн тодорхой хувийг улсаас, үлдсэн хувийг эцэг эх төлнө. Бүртгэлийн маягтыг хоолны танхимаас авч болно. Хоолны мөнгийг эцэг эх инкасогоор данснаас төлөх, онцгой тохиолдолд бэлнээр төлж болно.

Сургуулийн төлбөр

Хичээлийн жилийн эхэнд тодорхой мөнгийг (голдуу 100-500 кроны хооронд) сургуулийн дансанд илгээн. Энэ нь сурагчдын хичээлийн дэвтэр, хэрэгсэл, зохиогдох ямар нэг арга хэмжээнд зарцуулагдана.

Гадаад иргэдийн интеграцчилалд туслах Координаторын үүрэг

Млада Болэслав хотын бага сургуулиудад энэхүү координатор ажилладаг болж байна. Одоогийн байдлаар 3, 8, 9-р сургуулиудад ажиллаж байна.

Гадаад иргэдэд туслах Координаторын үндсэн үүрэг:

- сурагчдыг сургуульд бүртгүүлэх, сургуулийн талаарх мэдээлэл болон эх хэл дээрх (товхимлыг украин, орос, вьетнам, англи, монгол, болгар хэлнээ хөрвүүлэв) товхимол дамжуулах,

- сургууль, эцэг эхтэй хамтран хүүхдийн дасан зохицолд туслах ажлын төлөвлөгөө зохиох, биелэлтийг 3-6 сар тутамд хянаж байх,
- хичээлээ нөхөж хийхэд нь туслах, сургууль дээр нь эсвэл өөр байгууллага дээр явагдах чех хэлний дамжаа олоход туслах,
- чех хэлний сургалт бүхий хүүхдийн зусланд явахыг санал болгох,
- чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх үйл ажллагаанд бүртгүүлэхэд туслах,
- шаардлага гарвал эцэг эхтэй нь хамтран сэтгэл зүйчээс зөвлөгөө авч хүүхдийн хичээл сургалтыг хөнгөвчлөхөд дэмжлэг болгох,
- гадаадаас ирсэн хүүхдийн талаар багшаас гадна бас нэгэн харьцах ажилтан болох,
- боломж гарвал хүүхэдтэй уулзаж, ангид нь байлцах, чех хэл болон бусад хичээлийн даалгавраа хийхэд нь тусалж байх.

Хэрвээ сургуульд гадаад иргэдэд туслах Координатор гэсэн ажилтан байхгүй бол тухайн сургууль удирдлагын бүрэлдэхүүнээс эсвэл багш нараас хэн нэгнийг томилж гадаад иргэдийн хүүхэд дасан зохицоход нь туслах, санаа тавих хариуцлага хүлээлгэнэ.

Сургуулийн зөвлөгөө өгөх газар

Ийм зөвлөгөө өгөх газар нь ихэнх тохиолдолд сургуулийн сэтгэл зүйч, тусгай багш, хүмүүжлийн зөвлөх багш, урьдчилан сэргийлэх ажлын арга зүйч, тусгай багшийн туслах ажилтан, сургуулийн удирдах ажилтнаас бүрдсэн баг байдаг.

Энэ багийнхны зорилго нь, боловсрол олгох орчинг аюулгүй, тааламжтай байлгах, тусламж шаардлагатай нэг эсвэл бүлэг хүүхэд, мөн онцгой авьяастай хүүхэдтэй ажиллах болно. Урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, шинэчлэх, уг салбарт багш нарын боловсролыг дээшлүүлэхэд туслах, сургуулийн тухайн үеийн байдлыг хянах, урьдчилан сэргийлэх ажил, мансууруулах бодис болон бусад зүйлтэй холбоотой асуудлаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх байгууллагатай хамтрах зэргээр ажиллана.



Сэтгэл зүйчийн үүрэг юу вэ?

Сургуулийн сэтгэл зүйч бол сургууль дээр зөвлөгөө өгөх, зөвлөлдөх, онош, дүгнэлт, аргачлал, мэдээлэл гаргах, сурагчид багш нар, эцэг эхтэй ажиллах үүрэгтэй.

Мөн сургуультай хамааралтай Сурган хүмүүжил-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх газар, Сургалт хүмүүжлийн тусгай төв, эрүүл мэнд нийгмийн хамгааллын, хүүхэд залуучуудын зэрэг байгууллагатай хамтран ажиллана.

Ямар тохиолдолд сургуулийн сэтгэл зүйчид хандах вэ?

Сурагчид дараах тохиолдолд сэтгэл зүйчид хандаж болно:

- ангийнхантайгаа ойлголцохгүй, хэрхэн шийдэхээ мэдэхгүй бол...
- хичээл сурлага өөрийн чинь хүссэнд хүрэхгүй бол,
- сэтгэл зовоож буй (айдас, өвчин, сэтгэл зоволт, бусад сурагчтай муудалцах...) зүйл байвал,
- гэрт чинь таагүй байдаг бөгөөд энэ талаар хуваалцах хүн байхгүй бол,
- үеийнхэн дундаа ганцаардаж буй бол,
- ямар нэг зүйлийн талаар ярилцах хэрэгтэй бол,
- сонгож буй сургууль, мэргэжилдээ эргэлзэж буй бол.

Дараах тохиолдолд эцэг эхүүд сэтгэлзүйчид хандаж болно:

- хүүхдээ хүмүүжүүлэхэд ямар нэг зүйл нь болохгүй бол,
- эцэг эх, ангийн багш хоорондын харилцаанд бэрхшээл гарвал,
- хүүхдийн сурлага зохих ёсоор болохгүй бол,
- хүүхдийн сэтгэл санаанд нөлөөлөх өөрчлөлт (салалт, өвчин...) тохиолдож буй бол,
- таны хүүхдэд асуудал (айх, найзууддаа гомдох, дуугаа хураах г.м.) гарч буй бол,
- та хямралтай байгаа бол (орчноо солих, өвчин, гэр бүл салалт...).

Зөвлөгөө авах нь сэтгэл хөнгөрөх, шийдэл олох зэрэгт туслах ихээхэн ач холбогдолтой байдаг.

Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх газрын шийдвэрт үндэслэсэн дэмжлэг

Чех хэл мэдэхгүй гадаад хүүхдэд зарим сургууль сэтгэл зүйчид хандахыг зөвлөдөг бөгөөд сэтгэлзүйч тухайн хүүхдийн хичээл сурлагад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, жишээ нь шалгалтын цагийг сунгах, багшаар зөвхөн дүн биш мөн тодорхойлолт бичүүлэх г.м. арга хэмжээ авдаг. Энэ нь хүүхдэд ямарваа онош дүгнэлт хийх, бусдаас онцлох “муу тэмдэг” тавьж буй хэрэг биш, харин мэргэжлийн зөвлөгөөнд үндэслэн тус дэм болох боломжийг нэмэгдүүлэх системийг ашиглах юм.

Сургуулийн жирийн нэг өдөр ямар байдаг вэ?

1. Хүүхэд сургуульдаа ирнэ, ангийнхаа хувцасны өрөөнд гадуур хувцсаа тайлан гутлаа сольж өмсөнө.
2. Хүүхэд ангидаа орж хичээлдээ бэлдэнэ.
3. Нэг хичээл 45 минут үргэлжилнэ.
4. Хоёр хичээлийн дараа цай уух их завсарлага болно.
5. Дараагийн хоёр эсвэл гурван хичээлийн дараа үдийн хоолны цаг болно.
6. Үүгээр хичээл дуусна. 3-р ангиас эхлэн долоо хоногт 2 удаа (хоёр хичээл илүү) үдээс хойш ордог болно.

ХҮҮХДЭЭ БАГА СУРГУУЛЬД ХЭРХЭН БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

6 нас хүрсэн хүүхэд бүр сургуульд биечлэн бүртгүүлнэ. Энэ бүртгэл нь тухайн хүүхэд сэтгэл санаа болон нийгэмшлийн хувьд сургуульд суралцахад бэлэн эсэхийг шийдэх хариуцлагатай үйл явдал юм.



Бүртгэлийн эхний алхам нь “2021/2022 хичээлийн жилд хүүхдэд суурь боловсрол эзэмшүүлэх хүсэлт, 1-р ангид элсүүлэх тухай өргөдөл”-ийг бөглөнө. Эдгээр өргөдлийн маягтыг тухайн сургуулийн вэб хуудсаас татаж авах, эсвэл сургууль дээр ирж авах боломжтой. Өргөдлийг тодорхой хугацааны дотор тухайн сургуульдаа өгөх ёстой. Бүртгэл 4-р сард явагддаг.

Бүртгэлийн хоёр дахь алхам нь сургууль дээр хүүхдийн чадварыг дүгнэх юм.

Хичээлийн жилийн дундуур хүүхэд сургуульд орох бол “Өөр сургуулиас шилжин суралцах/...-р ангид оруулах тухай өргөдөл - асуулга” бөглөж бусад шаардлагатай биичг баримтын хамт сургууль дээр өгнө.

ТОГТМОЛ ХЭРЭГЛЭГДДЭГ ҮГС

Сурагчийн дэвтэр (žakovská knižka – жаковска книжка)

Сурагчийн дэвтэр дээр ихэвчилэн хичээлийн дүнг бичдэг. Түүнчилэн, мөнгө төлбөр дуусаж буй, зохиогдох арга хэмжээний төлбөрийг хийх, аялалд явах тухай зэрэг мэдээллийг багшаас эцэг эхэд бичдэг. Мөн сурагчийн ямар нэг доголдол, түүнийг засах талаар эцэг эхэд шаардлага тавина. Сурагчийн цаасан дэвтрийг өнөө үед нэг, хоёрдугаар ангид голдуу хэрэглэж байна.

Даалгаврын дэвтэр (úkolníček – уколничэк)

Жижиг хэлбэртэй цаасан дэвтэр байдаг бөгөөд үүнийг дэлгүүрээс худалдаж авахыг сурагчаас шаардана. Энэ дэвтэрт тодорхой хугацаанд хийж гүйцэтгэх даалгаврыг бичдэг.

Эцэг эхийн зөвлөл (rodičovská rada – родичовска рада)

Эцэг эхийн зөвлөл нь ангийн сурагчдын эцэг эхийг төлөөлөн сонгогдсон бие даасан субъект юм. Зөвлөл эцэг эхчүүдээс цугларсан мөнгө санхүү, ивээн тэтгэлтийг зохицуулна. Орлого зарлагыг бүртгэн тооцож тогтмол ил тод мэдээлж байна.

Сурагчдын буюу сургуулийн парламент (školní parlament – школни парламэнт)

Сурагчдын парламент гэдэг нь тухайн сургуулиас сонгогдсон сурагчдын бүлгэм юм. Анги бүр хоёр төлөөлөгчөө парламентэд оруулах дүрэмтэй. Төлөөлөгчид нь сургууль дээр юуг сайжруулж болох тухай саналыг ангиасаа цуглуулна. Хоёр долоо хоногт эсвэл сард нэг удаа тогтмол явагддаг парламентийн хуралд эдгээр саналыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Хийгдсэн ажлын талаарх мэдээллийг ангийнхандаа тогтмол хүргэж байна.

Өдөр өнжүүлэх бүлэг (družina – дружина)

Энэ нь мэргэжлийн багшийн удирдлага дор хичээл эхлэхийн өмнө болон дууссаны дараа сургууль дээр байдаг хүүхдийн зохион байгуулалттай бүлэг. Энэ бүлэгт хүүхдүүд хүмүүжүүлэгч буюу бүлгийн удирдагчтай хамт гэрийн даалгавраа хийх, тоглох, агаар салхинд гарах зэргээр цагийг өнгөрүүлнэ. Хичээл хэлэхээс өмнө ажилдаа явдаг, эсвэл хичээл дууссан даруйд хүүхдээ авах боломжгүй гэр бүлд зориулагдсан бүлэг. Өдөр өнжүүлэх бүлэгт бага зэргийн төлбөр төлдөг.

Эцэг эх нь хүүхдээ өглөөний (6:30-аас голдуу эхэлдэг) эсвэл үдээс хойшхи (хичээл дууссаны дараа эхэлж 16 цагийн үед тардаг) бүлэгт өгөх эсэхээ шийднэ. Хүүхдээ өдөр өнжүүлэх бүлэгт оруулах өргөдлийн маягтыг сургуулийн вэб сайтаас авч, эсвэл хүүхдээ сургуульд бүртгүүлэх үед, эсвэл сургуульд ороод хийх анхны эцэг эхийн хурал дээр бөглөж бүртгүүлдэг. А Бүлэг зөвхөн 1-3-р ангийнханд зориулсан, гэхдээ зарим сургууль үүнээс дээшхи ангийн хүүхдэд зориулан зохион байгуулдаг.

Хөнгөн хүнс, завсарлага (Svačiny a přestávky – свачини а пржэставки)

Хүүхдүүд хичээл бүрийн дараа 10 минутын завсарлагатай байдаг. Хоёр хичээлийн дараа 20 минут үргэлжлэх их завсарлагатай. Хүүхдүүд гэрээсээ авчирсан, эцэг эхийнхээ бэлдэж өгсөн хүнсийг хэрэглэх боломжтой. Хүүхдүүд өдөр бүр хөнгөн хүнс, ялангуяа уух шингэн зүйл хангалттай бэлдэж авчрах нь чухал.

Биеийн тамир (Tělesná výchova – телэсна вихова)

Сургалтын төлөвлөгөөнд ордог хичээлийн нэг төрөл. Хүүхдүүд биеийн тамирын хичээлд цагаан ултай зориулалтын гутал болон биед тохирсон эвтэйхэн хувцастай ирэх дүрэмтэй. Өвлийн улиралд дулаан хувцастай ирнэ.



Байгаль дахь хичээл, цанын сургалт, аялал (Škola v přírodě –школа в прприроде, lyžařský kurz – лижарски курз, výlety – вилэти)

Хүүхдүүд ангиараа аялал (нэг ба олон өдрийн), цанын сургалт, байгальд заах хичээл зэрэгт оролцох боломжийг сургууль олгодог. Төлбөрийг эцэг эх төлнө.

МЛАДА БОЛЭСЛАВ ДАХЬ БАГА СУРГУУЛИУД

1. БАГА СУРГУУЛЬ

Komenského náměstí 76, 293 01 Mladá Boleslav,
төрийн байгууллага



ХАЯГ	Komenského náměstí 76, 293 01 Mladá Boleslav		
Захирал	Вацлав Колман, магистр	vaclav.kolman@1zsmb.cz	+420 326 321 572
Нарийн бичгийн дарга	Хана Бартошова	hana.bartosova@1zsmb.cz	+420 326 321 572
Гадаад иргэдийн интеграцчилал хариуцсан ажилтан	PaedDr. Ивана Ружичкова	ivana.ruzickova@1zsmb.cz	+420 326 321 572
Сурагчдын дундаж тоо	270	ВЭБ ХУУДАС	www.1zsmb.cz
Урьдчилан сэргийлэх ажлын арга зүйч	Ирена Павласкова, магистр	irena.pavlaskova@1zsmb.mb	
Сургуулийн сэтгэл зүйч	Ян Чапэк, маг. инж.	jan_capek@volny.cz	
Хүмүүжлийн зөвлөх	PaedDr. Ивана Ружичкова	ivana.ruzickova@1zsmb.cz	+420 326 321 572
Сургуулийн тухай	<p>Манай сургууль боловсролын тусгай хэрэглээтэй хүүхэд сурах ангиудыг санал болгодог. Заагдах хичээл нь энгийн бага сургуулиас ялгаагүй боловч заах арга, сурагчидтай ажиллах арга барил тусгай түвшинд байдаг.</p> <p>Нэг ангид дээд тал нь 14 сурагчтай байхыг хичээдгээрээ ихээхэн ялгаатай. Энэ нь, багш сурагчтай ганцаарчлан ажиллах боломж илүүтэй гэсэн үг.</p> <p>Унших чадварыг чанартай хөгжүүлэх “SFUMATO” сургалтын аргыг Млада Болэславд зөвхөн манай сургууль нэвтрүүлсэн. Боловсролын хөтөлбөрийн хүрээнд сургуулийн уламжлалаа үргэлжлүүлэн, үйлчилгээгээ улам өргөжүүлсээр байна.</p>		
Нэмэлт хичээл санал болгодог эсэх	Тийм		
Гадаад хүүхдэд чех хэлний нэмэлт сургалт санал болгодог уу?	Шаардлагатай бол тийм.		

2. БАГА СУРГУУЛЬ

Komenského náměstí 91, 293 01 Mladá Boleslav,
төрийн байгууллага



ХАЯГ	Komenského náměstí 91, 293 01 Mladá Boleslav		
Захирал	Матей Повшик, магистр, бакалавр	matej.povsik@2zsmb.cz	+420 326 329 714
Нарийн бичгийн дарга	Марцэла Свободова	info@2zsmb.cz	+420 326 321 794
Гадаад иргэдийн интеграцилал хариуцсан ажилтан	Симона Шванингэрова, магистр.бакалавр	simona.schwaningerova @2zsmb.cz	+420 604 227 485
Сурагчийн дундаж тоо	592	ВЭБ ХУУДАС	www.2zsmb.cz
Урьдчилан сэргийлэх ажлын арга зүйч	Вэроника Брэйхова, маг.	veronika.brejchova@2zsmb.cz	
Сургуулийн сэтгэл зүйч	Михаэла Жакова, маг.	zakova.michaela@gmail.com	
Хүмүүжлийн зөвлөх	Симона Шванингэрова, магистр	simona.schwaningerova @2zsmb.cz	+420 604 227 485
Сургуулийн тухай	<p>Манай сургууль орчин үеийн сургалтад зориулсан маш сайн тохижилт, хангамжтай. Биеийн тамирын гурван танхим, компьютерийн хоёр танхим, хэлний гурван анги, лаборатор бүхий байгаль орчны сургалт, гэр ахуйн байр, хөдөлмөрийн хичээлийн өрөө, таблет ашиглан явагддаг төрөлжсөн сургалтуудтай.</p> <p>Гадаад хэлд чиглэсэн сургалтын өөрийн хөтөлбөртэй. Сургалтын хүрээнд гадаад хэлний мэдлэгийг сайжруулах зорилгоор сурагчдыг гадаад явуулдаг.</p> <p>Сурагчдын бие даалт, өөртөө итгэх итгэл, хариуцлага, өөрийгөө таних талыг хөгжүүлэхийг хичээдэг. Үр дүнтэй суралцах, бүтээлч талыг нь хөгжүүлэхэд анхаардаг. Хамт олон дотроо хамтач, хянамгай, журам дүрмийг баримталдаг болоход чиглүүлнэ</p>		
Нэмэлт хичээл санал болгодог эсэх?	Шаардлага гарвал тийм.		
Гадаад хүүхдэд чех хэлний нэмэлт сургалт санал болгодог эсэх?	Урьдчилан тохиролцож ганцаарчилсан сургалт явуулж болно.		

Др. ЭДВАРД БЭНЭШИЙН БАГА СУРГУУЛЬ

Laurinova 905, 293 01 Mladá Boleslav,
Төрийн байгууллага



ХАЯГ	Laurinova 905, 293 01 Mladá Boleslav		
Захирал	Бригита Шулцова, маг.	brigita.sulcova@zsbeneze.cz	+420 775 677 724
Нарийн бичгийн дарга	Хана Балоунова	sekretariat@zsbeneze.cz	
Гадаад иргэдийн интеграцилал хариуцсан ажилтан	Олдржих Кисэла	okysela1@gmail.com	+420 602 541 200
Сурагчдын дундаж тоо	600	ВЭБ ХУУДАС	www.zsbeneze.cz
Урьдчилан сэргийлэх ажлын арга зүйч	Павла Чэрмакова, магистр	pavla.cermakova @zsbeneze.cz	+420 326 324 075
Сургуулийн сэтгэл зүйч	Марцэла Дразска, магистр	marcela.drazska@centrum.cz	+420 724 233 430
Сургуулийн тухай	Манай сургууль нэг ба хоёрдугаар түвшний сургалттай. 2019 онд өргөтгөл хийж химийн лаборатор, химийн, компьютерийн, хэлний хичээлийн танхимууд шинээр байгуулсан. Хоккейн спортоор хичээллэх сонирхолтой сурагчдыг бид дэмждэг.		
Нэмэлт хичээл санал болгодог эсэх?	Багштай тохиролцож болно		
Гадаад хүүхдэд чех хэлний нэмэлт сургалт санал болгодог эсэх?	Одоогоор үгүй. Зөвхөн тухайн сурагч ганцаарчилан хичээл заалгах шаардлагатай бол болно. Гэхдээ гадаад иргэдийн Координатор чех хэлний сургалтын талаар хамтрагч байгууллагуудтай тохиролцож болно.		

СУРГУУЛИЙН ТАЛААРХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Энэ сургуульд хүүхдээ хэрхэн бүртгүүлэх вэ?

1. Сургуулийн вэб хуудсаар дараах бүлэг рүү орж онлайн бүртгүүлнэ:
Škola - dokumenty - formuláře – энд “хүүхдэд суурь боловсрол эзэмшүүлэх хүсэлт,
-р ангид элсүүлэх тухай өргөдөл” байдаг.
2. Сургуулийн захиралтай холбогдох
3. Бүртгүүлэх өдөр ирэх

Зөвхөн нэгдүгээр ангид орох хүүхдийн бүртгэл явагдах өдрийг вэб хуудсаар мэдэгдэнэ. Өөр сургуульд хүүхэд шилжих тухайд захиралтай уулзана. Бүртгэлийн тухай захирамжийг хотын тамгын газраас гаргаж хотын вэб хуудаст мэдээлнэ.

Сургууль дээр дугуйлан ажилладаг уу?

Дараах дугуйлангуудаас тухайн хичээлийн жилд зарим нь өөрчлөгдөх нь байдаг:

1-р түвшингийн сурагчдад:

- Авьяаслаг хүүхдүүд – техникийн дугуйлан
- Утга зохиол драмын дугуйлан
- Хамгийн бяцхан хүүхдүүдэд зориулсан англи хэлний дугуйлан
- Сэтгэн бодолт, хөлөгт тоглоомын дугуйлан
- Керамик
- Спорт тоглоом
- Ажилсаг гар
- Сагсан бөмбөг

2-р түвшний сурагчдад:

- Хөгжилтэй сэтгэн бодолт, хөлөгт тоглоомын клуб
- Керамик
- Ирээдүйн робот зохиогч

Сургууль дээр хэн нэгэнтэй уулзах хэрэгтэй бол яах вэ?

Сургуулийн н.б.д. Хана Балоуновад имэйл бичиж болно: sekretariat@zsbene.cz.

Мөн Гадаадын иргэдэд туслах байгууллага “CIC” болон “CPIC”-ийн координатортой уулзаж орчуулагч авахад туслалцаа авч болно.

Хүүхдээ эмчид үзүүлэх бол яах вэ?- ангийн багшид мэдээлэх нь зүйтэй.

Тодорхой хугацаагаар юманд явах бол яах вэ? – ангийн багшид хэлж, захирлаас чөлөө авах (шалтгааныг тайлбарлах) ёстой – чөлөө хүссэн маягтыг вэб хуудсаас авч бөглөнө, хүүхэд гэртээ хийж болох хичээл даалгаврын талаар ангийн багштай тохиролцоно.

Хүүхэд өвдвөл яах вэ?- ангийн багшид заавал мэдээлнэ.

Бусад асуудлаар яах вэ?

Хэрвээ хүүхэд ямарваа шалтгаанаар биеийн тамирт орж чадахааргүй бол энэ хичээлээс чөлөөлүүлэх хүсэлт (вэб хуудасны “formuláře” хэсэгт бий) өгөх хэрэгтэй.

Сургуульд юуны төлбөрүүд хийгддэг вэ? (ихэнхдээ бусад сургуулийн адил)

- Үдийн хоол – дансанд шилжүүлэх
- Өдөр өнжүүлэх бүлэг – 3-р анги хүртэлх хүүхдүүд
- Тодорхой сурах бичиг, дэвтэр
- Ангийн хуримтлалын сан – ангид хуримтлал байгуулж аялал г.м. зүйлд зарцуулна – бэлэн мөнгөөр цуглуулж ангийн багшид өгнө
- Сонгогдсон дугуйлан – сургууль дээр зөвхөн явагдах дугуйлангаас
- Байгаль дахь хичээл – ЭМ-д тустай энэ хичээлд жилд нэг удаа ангиараа явна.
- Сургуулийн аялал
- Цанын сургалт – хүүхэд өөрөө хүсвэл уулан дахь цанын сургалтад явж болно
- Гэрэл зураг – хичээлийн жилийн эцэст, зарим үед зул сарын үеэр ангиараа зургаа авахуулах (хувийн мэдээллийн зөвшөөрөл GDPR-д эцэг эх гарын үсэг зурна)
- Өөр бусад зүйлсийн талаар бол юуны төлбөр ямар дансанд илгээхийг багш нь эцэг эхэд ямагт мэдээлдэг.

Т. Г. МАСАРИКИЙН БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ

Svatovítská 574, 293 01 Mladá Boleslav,
Төрийн байгууллага



ХАЯГ	Svatovítská 574, 293 01 Mladá Boleslav		
Захирал	Милоуш Кашпар, магистр	kaspar@4zsmb.cz	+420 725 122 381
Нарийн бичгийн дарга	Станислава Жантова	sekretariat@4zsmb.cz	+420 725 122 387
Гадаад иргэдийг хариуцсан ажилтан	Бланка Свободова, магистр	svobodova@4zsmb.cz	+420 725 122 387
Сурагчдын дундаж тоо	300	ВЭБ ХУУДАС	www.4zsmb.cz
Урьдчилан сэргийлэх арга зүйч	Бланка Свободова	svobodova@4zsmb.cz	
Сургуулийн сэтгэлзүйч	Пэтра Валэнтова	psycholog@4zsmb.cz	
Хүмүүжлийн зөвлөх	Пэтра Валэнтова	psycholog@4zsmb.cz	+420 326 321 572
Сургуулийн тухай	Манай сургууль стандарт жирийн сургууль. Тогтмол үйл ажиллагаанаас гадна сургуулийн логопед (хэл яриа заслын эмч) ажилладаг. Түүнчилэн хүүхдүүд бичгийн, чех хэлний, гитарын, төгөлдөр хуур, лимбэ, атлетик зэрэг оолон дугуйланд явах боломжтой.		
Нэмэлт хичээл санал болгодог эсэх?	Тодорхой багш нартай тохиролцсоны үндсэн дээр болно.		
Гадаад хүүхдэд чех хэлний нэмэлт сургалт санал болгодог эсэх?	Үгүй, гэхдээ чех хэлний дугуйланд явж болно.		

5. БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ

Dukelská 1112, 293 01 Mladá Boleslav,
Төрийн байгууллага



ХАЯГ	Dukelská 1112, 293 01 Mladá Boleslav		
Захирал	Марцэла Павликова, магистр	pavlikova@5zsmb.cz	+420 326 211 171
Нарийн бичгийн дарга	Милэна Кралова	5zsmb@5zsmb.cz	+420 326 211 170
Гадаад иргэдийг хариуцсан ажилтан	Тэрэза Свободова, магистр	svobodova@5zsmb.cz	+420 326 211 170
Сурагчдын дундаж тоо	500	ВЭБ ХУУДАС	www.5zsmb.cz
Урьдчилан сэргийлэх арга зүйч	Тэрэза Свободова, магистр	svobodova@5zsmb.cz	+420 326 211 181
Сургуулийн сэтгэл зүйч	PhDr. Зузана Кнэсплова	knesplova@5zsmb.cz	
Хүмүүжлийн зөвлөх	Лэона Новакова, магистр	novakova@5zsmb.cz	
Сургуулийн тодорхойлолт	<p>Бид сурагчдынхаа эрүүл мэндийг дэмжин идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг. Гадаад хэл сургалт, эколог төслүүд, амьдралын зөв зарчмыг баримтлахыг дэмжих хөгжүүлэх талаар эрчимтэй ажилладаг.</p> <p>Хүүхдүүд чөлөөт цагаа утга учиртай өнгөрөөхөд нь зориулж хичээлээс гадуур олон арга хэмжээ зохион байгуулдаг.</p> <p>Сургуулийн хоолны танхимд “Е” бодисгүй хүнсээр үйлчлэхийг хичээдэг.</p>		
Нэмэлт хичээл санал болгодог эсэх?	Тийм		
Гадаад хүүхдэд чех хэлний нэмэлт сургалт санал болгодог эсэх?	Тийм		

6. БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ

Jilemnického 1152, 293 01 Mladá Boleslav,
Төрийн байгууллага



ХАЯГ	Jilemnického 1152, 293 01 Mladá Boleslav		
Захирал	Томаш Сухи	tomas.suchy@6zsmb.cz	+420 326 201 912
Нарийн бичгийн дарга	Вера Климэшова	info6zs@6zsmb.cz	+420 326 201 911
Гадаад иргэдийг хариуцсан ажилтан	Катэрижина Крэйчикова	katerina.krejcikova@6zsmb.cz	+420 326 201 913
Сурагчдын дундаж тоо	690	ВЭБ ХУУДАС	www.6zsmb.cz
Урьдчилан сэргийлэх арга зүйч	Вэроника Ханчова, магистр	veronika.hancova@6zsmb.cz	
Сургуулийн сэтгэлзүйч	Отакар Паточка, магистр	psycholog6zs@6zsmb.cz	+420 326 201 927
Хүмүүжлийн зөвлөх	Катэрижина Крэйчикова, Вэроника Виншова, магистр	katerina.krejcikova@6zsmb.cz veronika.vinsova@6zsmb.cz	+420 326 201 913
Сургуулийн тухай	<p>Тайван эерэг орчинг онцлон бүрдүүлж сурагчдын оюуны хөгжилт, спортлог чадварыг дэмждэг. Биеийн тамирын өргөтгөсөн хичээлийн төрлүүд, атлетик зэрэг бүх нийтийн спортод анхаарахаас гадна хоёрдугаар түвшний сурагчдад сонгон суралцах англи хэл, мэдээлэл зүй, байгалийн ухааны дадлага санал болгоно.</p> <p>Сургуулийн боловсролын хөтөлбөр нь хувь хүний шаардлага, боломжит дээд чадавхид чиглэнэ. Сурагчдын идэвх санаачлага, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой. Мөн тэдний боломж боллоцоог харгалзана.</p> <p>Биеийн тамир, спортын хичээл, ерөнхий боловсролын хичээлийн төрлүүд, үндсэн мэдлэг чадварын хөгжилтөд онцгойлон, мөн сурагчдын хэлний мэдлэгт анхаарал тавьдаг.</p>		
Нэмэлт хичээл санал болгодог эсэх?	Шаардлагатай бол нэмэлт хичээл санал болгодог.		
Гадаад хүүхдэд чех хэлний нэмэлт сургалт санал болгодог эсэх?	Шаардлагатай бол гадаад хүүхдэд чех хэлний нэмэлт хичээл санал болгоно, үүнд хэрэглэгдэх материал хэрэгсэл байдаг. Сургуулийн асистент үүнд мөн дэмжлэг үзүүлнэ.		

7. БАГА СУРГУУЛЬ

Václavkova 1082, 293 01 Mladá Boleslav,
Төрийн байгууллага



ХАЯГ	Václavkova 1082, 293 01 Mladá Boleslav		
Захирал	Милада Мизэрова	miladamizerova@seznam.cz	+420 326 733 947
Нарийн бичгийн дарга	Пэтра Марчэкова	zs7mb@seznam.cz sekretar@seznam.cz	+420 326 733 971 +420 326 733 951
Гадаад иргэдийг хариуцсан ажилтан	Рэната Холанова, магистр	ren.hol@seznam.cz	+420 723 329 005
Сурагчдын дундаж тоо	800	ВЭБ ХУУДАС	www.zs7mb.cz
Урьдчилан сэргийлэх арга зүйч	Катэргжина Сморчкова, магистр Владимира Марушкова, магистр	smrckova.k@seznam.cz vladimira.maruskova@seznam.cz	
Сургуулийн сэтгэлзүйч	Mgr. Otakar Patočka	psycholog6zs@6zsmb.cz	+420 326 201 927
Хүмүүжлийн зөвлөх	Милада Мизэрова Дагмар Шимонова, магистр	miladamizerova@seznam.cz simonova.d@seznam.cz	
Сургуулийн тухай	Энэхүү долдугаар сургууль нь Млада Болэслав хотын тамгын газраас зохицуулагдсан хамгийн том сургууль билээ. Уг сургууль теник төхөөрөмж сайтай, төрөлжсөн хэд хэдэн танхимтай, шинээр тохижуулсан хөдөлмөрийн танхимтай. Компьютерийн хоёр ангитай. Сурагчид эрүүл мэндэд тустай аялал, спорт сургалт, байгаль дахь хичээл зэрэгт оролцох боломжтой. Тогтол хичээллэдэг төрөл бүрийн дугуйлантай.		
Нэмэлт хичээл санал болгодог эсэх?	Багш нартай тусгайлан тохиролцож болно.		
Гадаад иргэдэд чех хэлний нэмэлт хичээл	Одоогийн байдлаар бүлгээр хичээллэх нэмэлт сургалт байхгүй. Шинээр ирсэн гадаад сурагчид чех хэлний хичээлээс гадна ганцаарчилан нэмэлт сургалт явуулна.		

8. БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ

Václavkova 1040, 293 01 Mladá Boleslav,
Төрийн байгууллага



ХАЯГ	Václavkova 1040, 293 01 Mladá Boleslav		
Захирал	Еитка Хоуштэцка, магистр	houstecka@8zsmb.cz	+420 326 997 473
Нарийн бичгийн дарга	Ива Сэглова	seglova@8zsmb.cz	+420 326 733 867
Гадаад иргэд хариуцсан координатор	Вэроника Дединова	dedinova@8zsmb.cz	
Сурагчдын дундаж тоо	560	ВЭБ ХУУДАС	www.8zsmb.cz
Урьдчилан сэргийлэх арга зүйч	Отто Росак, магистр	rosak@8zsmb.cz	
Сургуулийн сэтгэлзүйч	Зузана Сэдлачкова, магистр	sedlackova@8zsmb.cz	
Хүмүүжлийн зөвлөх, координатор	Здэнька Михалцова, магистр	michalcova@8zsmb.cz	+420 326 733 912
Мэргэжлийн чиг баримжааны зөвлөх	Ян Травницки, магистр	travnicky@8zsmb.cz	
Сургуулийн тухай	Манай сургууль орчин үеийн бүрэн зохион байгуулалттай бага сургууль бөгөөд нэгдүгээр түвшний 15 анги, хоёрдугаар түвшний 7 анги, 5 өдөр өнжүүлэх бүлэгтэй. Нэг ангид байх сурагчдын дундаж тоо: 1-р түвшин: 24 сурагч, 2-р түвшин: 22 сурагч		
Нэмэлт хичээл санал болгодог эсэх?	Тийм, сонирхвол ангийн багшдаа хандаарай.		
Гадаад сурагчдад чех хэлний нэмэлт сургалт санал болгодог эсэх?	Чех хэлний сургалт бид санал болгодоггүй, гэхдээ сонирхож буй бол гадаад иргэд хариуцсан Координаторт хандаарай.		

СУРГУУЛИЙН ТАЛААРХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Энэ сургуульд хүүхдээ хэрхэн бүртгүүлэх вэ?

1. Сургуулийн вэб хуудсаар бүртгэлийн маягт бөглөнө: <https://www.8zsmb.cz/formulare>.
2. Дарах дугаар луу утасдаж болно: 326 733 912.
3. Бүртгүүлэхээр сургууль дээр ирнэ – сургуульд зөвхөн шинээр орох хүүхэд.

Сургууль юугаараа өөр бөгөөд сонирхолтой вэ?:

- 1-3-р ангийн биеийн тамирын хичээлийг өргөжүүлэх боломж (1 цаг илүү),
- Теннис, мэдээлэл зүйн хичээл нэмэгдэх боломж,
- Хэл ярианы хөгжлийн багштай хичээллэх, сургалтын гажуудлыг засах боломж,
- Сэтгэлзүйч, тусгай багштай хичээллэх боломж,
- Орчин үеийн тоноглолтой ангиуд (компьютер, олон талт таблет, датапроектор),
- Нэгдүгээр ангийн хүүхдүүд ч хичээллэх мэдээлэлзүйн хоёр анги,
- Шавар бүтээл шатаах зуух бүхий керамик дугуйлан,
- Гадаад хэлний мультимедиа төхөөрөмж бүхий ангиуд,
- Төрөлжсөн тоног төхөөрөмжтэй анги танхимууд,
- Сургуулийн “Осминэк” сэтгүүл,
- Сурагчдын номын сан,
- Сүүн бүтээгдэхүүн нийлүүлэлт,
- Сургуулиудад жимсэн бүтээгдэхүүн,
- Сургалтын орчин үеийн аргачлал (төслийн сургалт, үйлдлийн сургалт, сургалт дадлага г.м.),
- Тэргэнцэртэй хүүхдэд зориулсан бартаагүй замтай сургууль.

Юуг онцлон анхаардаг вэ?

Сурагч бүртэй нэг бүрчилэн ажиллахыг чухалчилдаг.

Ямар дугуйлангууд ажилладаг вэ?

Дараах дугуйлангуудыг санал болгодог:

- Аяллын
- Гар урлал
- Керамик
- Тоглоом, англи хэл
- Флорбал
- Теннис
- Хөдөлгөөнт тоглоом
- Компьютер
- Найрал дуу
- Франц хэл
- Атлетик

Сургууль дээр хэн нэгтэй уулзахыг хүсвэл яах вэ?

Хэрвээ таны хүүхэд сургуульд явж буй бол Bakaláři вэб сайтаар дамжуулан, эсвэл имэйл бичиж, уулзах гэсэн багштайгаа тохирч болно. Багшид бичих имэйл хаяг (příjmení гэдэг үгийн оронд тухайн багшийн овгийг бичнэ): příjmení@8zsmb.cz. Хүүхэд тань уг сургуульд хараахан явдаггүй бол <https://www.8zsmb.cz/kontakty> хаягаар сургуулийн удирдлагад хандаж болно.

Хүүхдээ эмчид үзүүлэх бол яах вэ?

Хүүхдээ хэдэн цагт сургуулиас нь авах, эсвэл сургуульд нь хүргэж ирэх тухай ангийн багшид мэдэгдэхэд хангалттай. Эмчид үзүүлсэний дараа болон ер нь ямарваа чөлөө авахад чөлөө авах хуудас бөглөж өгөх, эсвэл Bakaláři-гаар дамжуулан мэдэгдэх ёстой.

Юманд тодорхой хугацаагаар явах бол яах вэ?

Хүүхдэд чөлөө хүсэх тухай өргөдөл бичиж сургуулийн удирдлагад өгнө.

Хүүхэд өвдвөл яах вэ?

Ажлын гурван өдөрт багтаан Bakaláři-аар, эсвэл имэйлээр бичиж мэдэгдэнэ.

9. БС ПАСТЭЛКА

БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ
17. listopadu 1325, 293 01 Mladá Boleslav,
Төрийн байгууллага



ХАЯГ	17. listopadu 1325, 293 01 Mladá Boleslav		
Захирал	Ива Коллинова, магистр	iva.kollinova@zspastelka.cz	+420 326 109 090
Нарийн бичгийн дарга	Алэна Мишнэрова, Хана Финкоусова	skola@zspastelka.cz	+420 326 327 623
Гадаад иргэд хариуцсан Координатор	Лилиа Шадкова, магистр	lilia.sadkova@zspastelka.cz	+420 725 539 839
Захирлаас томилогдсон, гадаад сурагчдыг хариуцсан Координатор	Ивана Козубова, магистр	ivana.kozubova @zspastelka.cz	
Сурагчдын дундаж тоо	550	ВЭБ ХУУДАС	www.zspastelka.cz
Урьдчилан сэргийлэх аргазүйч	Пэтра Сироваткова, магистр	petra.syrovatkova @zspastelka.cz	
Сургуулийн сэтгэлзүйч	Зузана Сэдлачкова, магистр	zuzana.sedlackova @zspastelka.cz	
ХБ хүүхэдтэй ажиллах нийгмийн ажилтан- сурган хүмүүжүүлэгч	Маркета Ридлова, магистр	marketa.rydlova @zspastelka.cz	
Хүмүүжлийн зөвлөх, 1-р түвшин	Ирэна Софинова, магистр	irena.sofinova@zspastelka.cz	
Хүмүүжлийн зөвлөх, 2-р түвшин	Ива Коллинова, магистр	iva.kollinova@zspastelka.cz	
Сургуулийн тухай	Боловсролд нэвтрэх, орчин үеийн технологийг нэвтрүүлэх зорилтот жирийн сургууль.		
Нэмэлт хичээл санал болгодог эсэх	Сурагчийн хувийн шаардлага, сонирхолд үндэслэнэ.		
Гадаад сурагчдад чех хэлний нэмэлт хичээл заах эсэх	Манай сургуульд чех хэлний хичээл заадаггүй. Хэрвээ ийм хичээл сонирхож буй бол гадаад иргэд хариуцсан Координаторт хандаж болно. Хэлний сургалт явуулдаг байгууллагуудтай Координатор холбогдож зохицуулна.		

Энэ сургуульд хүүхдээ хэрхэн бүртгүүлэх вэ?

1. Сургуультай холбогдох (утсаар, имэйлээр - www.zspastelka.cz вэб сайтаар орж уулзалт тохирох.
2. 1-р ангийн элсэлтийн бүртгэлд очих (дөрөвдүгээр сард).

Сургуулийн ялгаатай, сонирхолтой тал нь юу вэ?

“FK Mladá Boleslav”, “Basket Pastelka” зэрэг спорт клубүүдтэй хамтран ажилладаг.

Юуг онцлон анхаардаг вэ?

Хүмүүс хоорондын харилцаа, тогтоосон журам дүрмийг баримтлах, өөрийгөө бүрэн хариуцах.

Сургууль дээр дугуйлангууд явагддаг уу?

Зөвхөн өдөр өнжүүлэх бүлгийн хүрээнд дугуйлан ажиллана. Сургууль дээр мөн чөлөөт цаг өнгөрөөх олон төрөлт үйл ажиллагаа бүхий Урлагийн бага сургууль байрладаг.

Сургууль дээр багш нартай уулзах бол яах ёстой вэ?

Уулзах багштай имэйлээр харилцан цаг тохирно. Сургуулийн удирдлага, багш нартай холбогдох хаягийг дараах вэб хуудсаас авах, эсвэл утсаар холбогдож болно:

zspastelka.cz/vedeni-skoly
zspastelka.cz/ucitelsky-sbor
эсвэл сургууль руу утасдаарай.

Хүүхдээ эмчид үзүүлэх бол яах вэ?

Урьдчилан цаг авсан үзлэгтэй бол ангийн багшид сурагийн харилцах дэвтэр дээр бичиж мэдэгдэнэ. Нэгдүгээр түвшний ангийн хүүхдийг сургуульд эцэг эх биечлэн хүргэх, авах ёстой. Хоёрдугаар түвшний ангийн хүүхэд өөрөө явж байж болно.

Тодорхой хугацаагаар юманд явах шаардлагатай үед яах вэ?

Сургуулийн захиралд өргөдөл бичиж өгнө (маягтыг вэб сайтаас авна)

Хүүхэд өвчилбөл яах вэ?

Ажлын гурван өдрийн дотор имэйл эсвэл 326 327 623 дугаарын утсаар сургуульд мэдэгдэнэ. Хүүхэд хичээлдээ ормогц сурагчийн дэвтэр дээр энэ талаарх чөлөөг заавал бичнэ.

МАСАРИКИЙН БАГА СУРГУУЛЬ, “ДЭБРЖ” ЦЭЦЭРЛЭГ

Bakovská 7, 293 01 Mladá Boleslav - Debr',
Төрийн байгууллага



ХАЯГ	Bakovská 7, 293 01 Mladá Boleslav - Debr'		
Захирал	Якуб Чэрни, магистр	jakub.cerny@skoladebr.cz	+420 326 331 933
Нарийн бичгийн дарга	Яна Моравцова	zsdebr@seznam.cz	+420 326 325 973
Гадаад иргэдийн интегрцчилал хариуцсан ажилтан	Мартина Колэчкаржова, магистр	martina.koleckarova@skoladebr.cz	+420 724 760 631
Сурагчдын дундаж тоо	240	ВЭБ ХУУДАС	www.skoladebr.cz
Урьдчилан сэргийлэх арга зүйч	Мартина Колэчкаржова, магистр	martina.koleckarova@skoladebr.cz	+420 724 760 631
Сургуулийн сэтгэлзүйч	Маркэта Ридлова, магистр	psycholog@skoladebr.cz	+420 607 936 720
Хүмүүжлийн зөвлөх	Мартина Колэчкаржова, магистр	martina.koleckarova@skoladebr.cz	+420 724 760 631
Сургуулийн тухай	<p>Ихэвчилэн Хрдлоржээ, Дэбрж, Еозэфув Дул тосгоны сурагчдад зориулсан хотын захын жижиг сургууль.</p> <p>Бидний эн тэргүүний зорилт бол сурагчид хоорондын сайн харилцаа, тэдний дасан зохицолт, мөн эцэг эхүүдтэй сайн харилцаа тогооход оршино. Үүнд зориулсан арга хэмжээнүүд ч олноор зохиодог.</p>		
Нэмэлт сургалт санал болгодог эсэх	Тийм		
Чех хэлний нэмэлт хичээл заадаг эсэх	Ганцаарчилан заах шаардлагатай тохиолдолд тийм.		

МАНАЙ БУС НУТАГ ДАХЬ ГАДААД ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ БАЙГУУЛЛАГУУД

CENTRUM PRO INTEGRACI CIZINCŮ, o.p.s.

Гадаад иргэдийн интеграцчилалын төв

Бидний байршил

Соёлын ордон (Budova Domu kultury – хажуугийн хаалга, 1-р давхар, 109)

Хаяг: Dukelská 1093, 293 01 Mladá Boleslav

Утас: +420 735 174 517, +420 735 755 200, +420 731 512 726

E-mail: mboleslav@cicops.cz

Вэб хуудас: <https://www.cicops.cz/cz/>

Манай байгууллага хараат бус, төрийн бус бөгөөд Млада Болэславд арав дахь жилдээ ажиллаж байна. Бүхий л үйлчилгээг **ҮНЭГҮЙ** үзүүлдэг.

Дараах үйлчилгээ үзүүлнэ:

- Хүүхдүүдэд зориулсан чех хэлний хичээл; Насанд хүрэгсдэд зориулсан чех хэлний хичээл
- Хичээл нөхөн сургалт
- Нийгэм, хөдөлмөр эрхлэлтийн талаарх зөвлөгөө
- Нийгмийн идэвхтэй үйлчилгээ “Хэрмиона”

Эцэг эхчүүдэд:

- Сургуультай харилцахад туслах
- Сургуульд орох бэлтгэл ажилд туслах г.м.
- Орон байрны болон санхүүгийн асуудал шийдэхэд туслах
- Нийгмийн харилцаа тогтоох, сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- Албан байгууллагуудтай харилцахад туслах
- Сайн дурын ажилтан туслалцаа үзүүлэх (орчин, зан заншил соёлтой танилцуулахад)
- Хүүхэдтэй гэр бүлд хамтдаа оролцох үйл ажиллагаа зохиох
- Бусад асуудлаар мэргэжлийн зөвлөгөө авахад зуучлах

Хүүхдүүдэд:

- Сайн дурын ажилтан туслалцаа үзүүлэх (орчин, зан заншил соёлтой танилцуулах)
- Хоёр дахь хэл буюу чех хэлний хичээл
- Сургуульд орох бэлтгэл, нөхөн сургалт
- Чөлөөт цаг өнгөрөөх арга хэмжээ сонгох, эсвэл зохион байгуулах
- Дунд сургууль, хичээлийн төрөл, ажил сонгоход (залууст) туслах
- Залуустай нийгэм – сэтгэлзүйн ярилцлага хийх
- Мэргэжлийн бусад зөвлөгөө, зуучлал

ГАДААД ИРГЭДИЙН ИНТЕГРАЦЧИЛАЛЫГ ДЭМЖИХ ТӨВ, МЛАДА БОЛЭСЛАВ

Бидний байршил

Соёлын ордон (Budova Domu kultury –хажуугийн хаалга, 1-р давхар, 106)

Хаяг: Dukelská 1093, 293 01 Mladá Boleslav

Утас: +420 770 182 361, +420 770 173 139, +420 775 018 798

E-mail: icmladaboleslav@suz.cz

Вэб хуудас: www.integracnicentra.cz

Facebook: CPIC Středočeský kraj – Mladá Boleslav

БНЧУ-ын Дотоод хэргийн яамны Дүрвэгсдийг зохицуулах алба 2009 оноос Чех улсын арван мужид интеграцчилалын бодлого хэрэгжүүлж байна. Бүх үйлчилгээ **ҮНЭГҮЙ**.

Үзүүлэх үйлчилгээ:

- Нийгмийн асуудлын зөвлөгөө (хөдөлмөр эрхзүй, оршин суух асуудал, бичиг баримт дүйцүүлэн баталгаажуулах, бага дунд сургуульд бүртгүүлэх, ЭМД-ын асуудал г.м.)
- Хууль эрхзүйн зөвлөгөө
- Чех хэлний түвшин тогтоох, ярианы клуб
- Орчуулах, хэлмэрчлэх үйлчилгээ
- Нийгэм соёлын дамжаа
- Интернет өрөө, номын сан
- Тодорхой бүлгийн ажилтнууд
- Боловсрол, соёл, олон нийтийн арга хэмжээ, үндэстний цөөнх болон олонхийн уулзалт, дасан зохицолтыг дэмжих арга хэмжээнүүд.

ТАЛАРХАЛ

Уг товхимлыг бүтээхэд оролцсон дараах хүмүүст талархлаа илэрхийлье:

Даниэл Марэк, магистр, Млада Болэслав хотын орлогч дарга

Пэтр Достал, магистр, Млада Болэслав хотын Боловсрол, соёл, биеийн тамирын хэлтсийн эрхлэгч

Бага сургуулиудын захирлууд – хатагтай Еитка Хоуштэцка, магистр,
хатагтай Ива Коллинова, магистр,
хатагтай Бригита Шулцова, магистр

Млада Болэслав хотын Соёлын эрхлэгч, “Хүүхдэд олгох боломж” хандивын сангийн тэргүүн
Милан Прунэр

Тус хот дахь Гадаад хүүхдийн интеграцчилал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан
координатор Ива Крукстон, МА, Rhom

Вэроника Дединова, DiS, 8-р сургууль, гадаад иргэд хариуцсан координатор

Лириа Шадкова, магистр, 9-р сургууль, гадаад иргэд хариуцсан координатор

Олдржих Кисэла, Эдвард Бэнэшийн сургууль, гадаад иргэд хариуцсан координатор

Яна Сукэникова, ГИИДТ-ийн эрхлэгч, Млада Болэслав

Пэтра Баборовска, ГИИТөв, сургалт хариуцсан координатор

Барбора Матейкова, ГИИТ, нийгмийн ажилтан

Млада Болэславын “Хүүхдэд олгох боломж” хандивын сан – www.sanceprodeti.com

Зохиогчид:

Ива Крукстон, MA, Rhom
Вэроника Дединова, магистр
Олдржих Кисэла
Лилиа Шадкова, магистр
Ива Коллинова, магистр
Еитка Хоушгэцка, магистр

Хянан тохиолдуулсан:

Ива Крукстон, MA, Rhom
Еитка Хоушгэцка, магистр

Орчуулсан:

Базаржавын Мянганбаяр

Энэхүү товхимлыг бүтээхэд хамтран санхүүжүүлсэн:

Млада Болэслав, Боловсрол, соёл, биеийн тамирын хэлтэс,
Бүгд Найрамдах Чех Улсын Дотоод хэргийн яамны “Бүс нутгийн түвшинд гадаад иргэдийн
интеграцилалыг дэмжих төсөл”,
Млада Болэславын “Хүүхдэд олгох боломж” хандивын сан